



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 481

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай


Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1, 10 дугаар зүйл, 15 дугаар зүйлийн 15.12.2, 15.12.3, 15.12.9, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 40 дүгээр зүйлийн 40.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтууд, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2013 оны 12 дугаар сарын 16-ны хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудад тусгай зөвшөөрлийг хавсралтад зааснаар олгосугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /А.Эрдэнэтуяа /-д даалгасугай.

САЙД  Н.УДВАЛ



Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох байгууллагын нэр, чиглэл

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	"Өү Жи Юу" ХХК	"Үжин дент" шүдний клиникийн тусламж үйлчилгээ
2	Универсаль мед ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, оношлуур импортлох, ханган нийлүүлэх, худалдах
3	Шар бар ХХК	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез импортлох, ханган нийлүүлэх, худалдах
4	Зүтгэл фармацевтик ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх
5	Саннимол ХХК	Биологийн идэвхит бүтээгдхүүн ханган нийлүүлэх, импортлох
6	Новалинк ХХК-	Биологийн идэвхит бүтээгдэхүүн ханган нийлүүлэх, импортлох
7	Юнисити ХХК	Биологийн идэвхит бүтээгдэхүүн импортлох, худалдах